



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 07

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2014-2015 онд хамрагдсан иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгээс 41 иргэн 60447.7 мянга, 2015 онд Малчдын бүлэгт тоног төхөөрөмж худалдан авахад олгосон санхүүгийн дэмжлэгээс 4 бүлэг 5927.0 мянга, Хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхэлж буй иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгээс эргэн төлөлтөөс 39 иргэн 29666.6 мянга, нийт 96041.3 мянган төгрөгийн хөтөлбөрт олгосон санхүүгийн дэмжлэгийг санд төлөөгүй хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Баянхонгор аймгийн ХХҮГ-ын дарга, Сумын Засаг дарга, иргэнтэй хийсэн гурвалсан гэрээнд заасан иргэний эрх, үүргийн 4.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй", 4.1.7 дахь "Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

2517119

1. ХЭДС-аас хөтөлбөрт олгосон санхүүгийн дэмжлэгээс 96041,3 мянган төгрөгийн эргэн төлөлийн хугацаа хэтэрсэн авлагатай хүмүүсийг хуулийн байгууллагад шилжүүлэн зөрчлийг арилгах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн ХХҮГ-ын дарга Д.Амарсанаа, Дотоод хяналт, үнэлгээ шинжилгээний хэлтсийн дарга Д.Одонтунгалаг, ХЭДС-ийн мэргэжилтэн Д.Алтанцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ
ӨГСӨН:
АХЛАХ АУДИТОР _____ А.ЦЭЭНЯМ
ЗӨВШӨӨРСӨН: _____
БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА _____ Д.АМАРСАНАА
ХЭДС-ИЙН МЭРГЭЖИЛТЭН _____ Д.АЛТАНЦЭЦЭГ

